



МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ САХИЛГЫН ХОРОО

2017 оны 03 дугаар сарын 21-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот,

МХБХ-ны Сахилгын хороонд 2017 оны 03 дугаар сарын 18-ны өдөр “ДМЮ” клубын дасгалжуулагч Д.Нанжидын гаргасан гомдлыг МХБХ-ны Сахилгын хорооны гишүүдийн хурлаар хэлэлцээд ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. МХБХ-ны “Гүйцэтгэх хороо”-ны 2017 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн хурлаар батлагдсан “Тэмцээн зохион байгуулах журам”-ын 2.7-д заасны дагуу МХБХ-ны тэмцээн уралдаанд оролцож байгаа клуб, багууд 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс “Тоглогчдын шилжилт хөдөлгөөний цонх” нээгдсэнээр хүлээн зөвшөөрөн мөрдөж эхэлсэн тул “Дэрэн клуб болон тамирчин А.Мөнгөнтулгатай холбоотой гомдлоор Сахилгын хэрэг үүсгэн шалгах шаардлагагүй байна.
2. МХБХ-ны “Гүйцэтгэх хороо”-ны хурлаар батлагсан дүрэм, журам, шийдвэрт хяналт тавьж ажиллаагүй, техникийн алдаа гаргасан, хяналт сулруулсан Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Ө.Шижирт МХБХ-ны Сахилгын хорооны Дүрмийн 10-р зүйлд заасны дагуу сануулах арга хэмжээ авсугай.
3. Техникийн алдаа гаргаж хариуцлага алдсан Техникийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Жаргалд МХБХ-ны дотоод журмын дагуу арга хэмжээ авч хариу мэдэгдэхийг МХБХ-ны Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Ө.Шижирт даалгасугай.
4. МХБХ-ны “Тоглогчдын бүртгэл ба шилжилт хөдөлгөөний журам”-ыг дагаж мөрдөх, тамирчид багуудын хооронд хийгдсэн гэрээ лицензийг баталгаажуулах, бүртгэх, МХБХ-ны Удирдах байгууллагуудаас гарсан шийдвэрүүдийн клуб, гишүүд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах тодорхой арга хэмжээ авч 2017 оны 04 дүгээр сарын 15-ны дотор хариу мэдэгдэхийг МХБХ-ны Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Ө.Шижир /МХБХ-ны Техникийн хэлтсийн захирал Ш.Жаргалсайхан/ нарт даалгасугай



Ц.БАТСҮХ

Г.БАТЗАЯА

Л.ГЭРЭЛНЯМ

Б.ОДСҮРЭН